

Чингис Хаан – “Гурван Их Оршил”-ын үзэлтэн

Тамганы нууцаас

Тамга, тэмдэг олон янз. Өнөөг хүрч мал, боол харцсын имдэг (ᠮᠢᠨᠭᠡᠨ) эвэртэн туурайтан (ᠡᠪᠡᠷᠲᠡᠨ eberten хаад ноёд, эрх ямбатан, ихэс дээд болж, улмаар овог аймаг, төр улсын заларч өргөмжит, халдашгүй чанарын лийн утга учир нь давамгайлж, дүрс зүүх газар нь ч цаг цагт хувирч иржээ.

Тамганаа учир холбогдолгүй зүйл гэж нарийн учиртай. Тамганы үг дардасаас ыг мэдэх бэрх. Олноороо уламжилж Уламлан ирээгүй буюу цорын ганц зүйл цөөнгүй. Жишээлэхэд, Гүюг хаа тай байсан нь мэдэгдэхгүй байгаа.

Тамганы үг ба бариулын толгой толгойтой байна, тамганы уу, эсрэг зүгт байна уу Манжиас монголчуудад өгч толгой нэг зүгт чиглэсэн

амьтны дүрс бүхүй тамганы толгой гадагшаа буюу Манж руу харж байна гэсэн үг. Сүүл тал нь дотогшоо буюу монгол эзэн рүүгээ харж байна гэсэн үг. Толгой тал нь хүндэтгэлтэй, бөгс буюу сүүл тал нь доромж тал. Манайхан үүнийг эс анзаарна. Одоо цагийн Монгол төрийн Арслан бариулт тамга, Засгийн Газрын Арслан бариулт тамгануудын Арслангийн сүүл нь Эзэн рүүгээ харж байгаа нь туйлаас зохисгүй зүйл. Засч залруулах ёстой хэмээн олонтаа ярьж, бичиж байна даа (Засчихсан байхыг үгүйсгэхгүй). Уг нь, монголчууд толгой талыг хүндэлдэг, бөгс буюу сүүл талыг дорд үздэгсэн. Наад захын жишээ нь, Цагаан сараар ууц тавих ёсыг санахад л ойлгомжтой. Хүндэт хүн рүүгээ ууцны толгой тал нь чиглэсэн байдаг бол, сүүл тал нь үүд рүү хандсан байдаг билээ. Тамга үүнтэй яг адил ёс бэлгэдлийн утгатай. Тамганы үг ба бариулын толгой хоёр, эсрэг тэсрэг харсан байрлалтай байх ёстой. Эс бөгөөс, тамганы бариулд сийлсэн амьтны сүүл буюу бөгс тал нь эзэн рүүгээ харж, эзнээ, төрөө доорд үзсэн явдал болно. Одоо цагт, төр засгийн тамгыг үйлдэхдээ үүнийг машид чухалчлан үйлдэх учиртай. Тамганы бариулын толгой, тамганы үгийн толгой эсрэгцсэн байдалтай байвал, тамга дарахад сүүл тал нь гадагшаа харсан, толгой тал нь эзэн рүүгээ харж дарагдах тул, зүйд нийцнэ. Энд төрийн тамганы нууц хадгалагдана. Дээр цагт үүнийг Хаан ба Тамгач түшмэлээс өөр хэн ч мэдэх учиргүй. Тиймээс Тамгач түшмэлийг хамаа бус хүнээр тавьдаггүй, үе залгамжлуулдаг, ёс жаяг бичиг үсэг сайн мэддэг, ам битүү хүнийг сонгодог байсан (Хүннү-гийн тамгач түшмэлийн явдал сонгодог жишээ). Төрийн тамганы үсэг, бариулын байршил нь, одоогийн хэлээр, чанад нууцын зэрэглэлтэй буюу Төрийн Хархайрцагны бодлогод хамаарах зүйл. Бичиг зохиолд гарч ирэх болов уу хэмээн олон жил хайсан боловч огт олж үзсэнгүй. Бичигдээгүй хууль, тэмдэглэгдээгүй ёс гэж байдгийн нэг болов уу даа*



ирсэн зам чийр, нэр ус ч өөр өөр. Эхэндээ өмч imdeg им+ тэмдэг) төдий байснаа, сүүл рүүгээ туурайтан - нэн эртний өтгөс нэртомьёо), сийн зэргэ зиндаа эрх мэдлийг ялгах тэмдэг сүлд болж, туг хийр (kigiri/kiyur) нээ олсноор гүн ухаан, соёл иргэншил, бэлгэд- байдал, хэлбэр галбир, янз төрх, хадах

огт үгүй. Тамга, тамганы бариул хоёр ч тодорхой мэдэгддэг боловч, тамганы бариул- ирсэн тамгануудаас төсөөлж нэг болно. байдаг “Хаан тамга”-ны тухайд үл мэдэгдэх ны тамганы үг тодорхой боловч, ямар бариул-

хоёр ч сонин харилцаатай. Тамганы үг хаашаа бариулын толгойтой нэг зүгт байна гэдгээс их ёс шалтгаалдаг. байсан тамгануудын үг ба бариулын байдаг. Нэг зүгт чиглэсэн байдаг тул,

* Тамганы энэ нууцыг Санзайжамаа овогтой Данзантавхай гэдэг хүн надад ярьж цээжлүүлж байсан юм.

Данзантавхай гэдэг энэ хүн миний ээж Санзайжамаагийн Лхамын төрсөн дүү. Бид “Амбаа” гэж дуудна. Багадаа Ганданд шавилан сууж байгаад нутаг очсон юм гэнэ лээ. Монгол, төвд бичигтэй, номтой хүн байсан. Бидний багад, эгч ах бид гуравт төвд үсэг зааж байсан. Нүдэлж, цээжилж тогтоогоогүй бол саваа бариулаад зогсоодог асан. Би гэдэг хүн нэлээн таргилдуу, сахилгагүй, юмны учрыг олох гээд хавь төсрийнхөө хүнийг их “шалгаадаг” мөртөө, “га

ха ган аа жа ча жан аа” гаас огт хэтэрдэггүй, их зөрүүд, ядраад уйлахаараа нулимсаа унагахгүй гэж дээшээ хараад зогсоод байдаг хүүхэд байсан юм гэнэ лээ. Нэг өдөр, “За чи ч энэ номыг туулахгүй хүн шиг байна даа. Одоо цагийн номын хүн байх аа даа” гээд намайг орхисон. Дотно гадна сургууль соёлд яваад ирэхэд минь, багын паянгаас авхуулан сонин хачин зүйл надад их ярьж өгдөг байв. Би хүүрээс айдаг, зугтаамтгай. Тэгэхэд Амбаа маань “үхсэн хүнээс бүү ай, ямар ч хоргүй хөөрхий. Амьд хүнээс л болгоомжтой бай” гэж захидаг байсан. Золгох ёс зэрэг олон зүйлийг ярьж хөөрч, сэнхрүүлдэг байсны нэг нь, дээр өгүүлсэн тамганы тухай яриа.

Уламжлалыг барьж, тамганы бариулын толгой тал нь эзэн рүүгээ харж, сүүл талыг нь гадагш чиглүүлж үйлдсэн эртний нэгэн тамга надад буй (Үргэлжлэлийг “Үндсэн хуулиа зөрчсөн тамган хөшөө” гэдэг өгүүлэл, гуравдахь Ерөнхийлөгч Намбарын Энхбаяртай ярилцсан яриа, телевизийн бичлэгээс нэхэн үзнэ үү).

- ❖ Малчин монголчууд хад чулуу, морь малынхаа ташаан дээрээс өдөр бүр харж үзэж, ахуй амьдралдаа хэрэглэсээр байгаад энгийн зүйл мэт үзэгдэх болсон **онги(н)** (ᠣᠩᠭᠢ ᠲᠠᠮᠠᠭᠠ, onggi tamaᠭ-a) **тамга**, Самарканд хотод 1227 онд дэлдсэн, “Чингис Хаан” гэсэн араб бичээстэй зоосны магнайд заларсан байдаг ❶



Доктор Б.Нямаагийн «Монголын эзэнт улсын мөнгөн тэмдэгт. 1912» хэмээх нэрт цомгоос

- Түүхийн шинжлэх ухааны доктор, судлаач Ба.Нямаа, Соёлын гавьяат зүтгэлтэн, профессор Го.Аким, Онц Бүрэн Эрхэт элчин сайд профессор Ой. Нямдаваа нар “Онги” тамгыг “**Чингис Хааны сүлд**” хэмээсэн **анхдагч санаа**, дугаригийг “**нар**” (Х.Пэрлээ “Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь” бүтээлдээ онги тамгыг наран тамга гэсэн), хөндлөн зурамыг “**этүгэн**” гэсэн тайлбарт тал өгөх (ᠲᠠᠮᠠᠭᠠ ᠲᠠᠮᠠᠭᠠ tal-a ᠳᠭ᠋ᠦ) ялдар аа, нэмэн тайлбарлах нь:
Дорнодахин, түүний дотор Монголд “Хоёр Их” (ᠬᠣᠡᠷ ᠶᠡᠬᠡ qoyar yeke) гэсэн уламжлалт үзэл, шүтээн байсан. “Хоёр Их” гэдэг нь “Тэнгэр” (ᠲᠡᠩᠭᠡᠷ tngri), “Газар” (ᠭᠠᠰᠠᠷ ᠭᠠᠰᠠᠷ = etügen, этүгэн = delekei, дэлхий) хоёрыг хэлдэг. Нангиадаар 兩大 liǎng-dà.dài, солонгосоор 량{양} 대, оросоор “Небо и Земля” гэж тус тус орчуулдаг.
Хүний нийгэмд бол, хаан нь Тэнгэрийг, хатан нь Газрыг төлөөлнө. Хааныг тэнгэрээс заяат төрсөн хэмээх ба, хатан эхийг “этүгэн эх”, “эх этүгэн” (МНТ 3-113-3) гэж холбон хүндэлдэг асан. “Хоёр Их” гэдэг ойлголт нэн эртнээс, Хүннү (ᠬᠦᠨᠨᠦ = Хүн), дундад эртний монголд дэлгэр байсныг чулуун ном, шастир түүх, шүтээн бэлгэдэл маань бэлхэнээ гэрчилнэ.
Монголын Нууц Товчоонд л гэхэд, “Хоёр Их” буюу “Тэнгэр Газар”-ын үзэл, шүтээн шингэсэн дараах хэллэг гардгийг эшлэн толилуулбал:
“Тэнгэр Газараа хүч нэмэгдэж” (8-208-17,18; 11-260-11,30),
“Тэнгэр Газараа хүч нэмэгдэж, эрхэт Тэнгэрт нэрэйтэж эх этүгэнээ хүргэж” (3-113-3,4),
“Тэнгэр Газараа хүч нэмж ихээгдвээс” (3-125-9,10),
“Мөнх Тэнгэрийн хүчин-дор Тэнгэр Газараа хүч аугаа нэмэгдэж” (9-224-8,9) болно.
Эдгээр нь цөм Чингис Хааны үг тул, “Хоёр Их”-ийн үзэл нь Монгол нутагт идээшсэн үзэл, Чингис Хаан өөрөө “**Хоёр Их**”-ийн үзэлтэн байжээ гэж хэлэх бүрэн үндэстэй байна.
“Онги” тамга дугариг, босоо, хөндлөн гурван мах бодоос бүрдэнэ. Дугариг нь “Тэнгэр” эсвэл “Нар”, хөндлөн нь “дэлхий” буюу “этүгэн”. “Нар” (=Тэнгэр), “дэлхий” хоёрын дунд байгаа босоо зурам нь “хүн”-ийг төлөөлнө. Дорнодахины гүн ухаанд ертөнцийн “Гурван Их Оршил” гэж хэлэлцдэг. Нангиадаар 三大存(在) sān-dà,dài-cún-(zai), солонгосоор 삼대존(제) хэмээнэ. Тэр нь “нар”, “дэлхий”, “хүн” гурвыг хэлдэг.
“Гурван Их Оршил” гэдэг ойлголт Монгол газар, монгол түмэнд ч түгээмэл байсан тул “Онги тамган”-даа шингээн авч үлдсэн аж.
Чингис Хаан “Хоёр Их”, “Гурван Их Оршил”-ын гүн ухаан, уугал утга, учир холбоог сайтар мэддэг байснаар барахгүй, дархлан мөнхөлж, сүлдээ болгосон байнам. Ийнхүү Чингис Хаан нь, “Хоёр Их”-ийн шүтээнт, “Гурван Их Оршил”-ын бэлгэдэлт аугаа удирдагч байжээ. Энэ бол монгол түмний бахархал. Санаагаар болдогсон бол, **Чингис**

Хааныхаа эл сүлдийг одоо цагийн **Монгол Улсынхаа сүлд болгон улируулан залбаас** юутай сайн(төрийн сүлдээ өөрчлөх сураг гарах болсон. Энэ жилийн наадмын арын чимэгт **Чингис Хааны хөрөг зургийн оройд онгин тамга** харагдсан. Ерөнхийлөгч маань Чингис Хааныхаа хөргийг өрх бүр залах тухай Зарлиг буулгасан байсан. Энэ бүгд нэгийг өгүүлж байгаа болов уу хэмээн дотор баясна).

Чингэвээс, жинхэнэ монгол суу ухаан, уламжлал бэлгэдэл амилахаас гадна, дэлхий дэхиний оюуны мэлмийг мялааж, эрдмийн сонорыг сэртийлгэх(**ᠰᠡᠷᠲᠡᠶᠢᠯᠭᠡᠬᠦ** sertyilgekü) нэгэн сэжүүр нахиална.

Басхүү “Гурван Их Оршил” буюу “тэнгэр”, “газар”, “хүмүүн”ий **гурван эрдэмд нэвтэрснийг “Богд”**(**ᠪᠣᠭᠳᠠ** boᠭda) хэмээдэг байсан (Чингисийг “Богд” хэмээдэг байсан нь ийм учиртай) нь, монголчуудын узуурын бэлгэдэл (**ᠴᠢᠵᠢᠭᠤᠨ ᠪᠡᠯᠭᠡᠳᠡᠯ** ujuyur-un belgedel)тэй яв цав тохирч өнө амьдарсаар бидний үед уламжлан ирсэн түүхтэй.

Юү ч атугай, бид монголчууд, сайнмуу хэлүүлж, өөдөлж доройтож явахдаа Чингис Хааныхаа **сүлд шүтээнийг** ар өвөртөө нууж, оюун санаандаа тээсээр авч үлдсэн, эрин зуун, хэн хүний өмнө нүүр бардам түмээн !